



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/178

Мандалговь

Г Архи, согтууруулах ундаа худалдах
түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай
зөвшөөрлийн эрх олгох тухай Г

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Нэгдүгээр хавсралтад дурьдсан Дундговь аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2019 оны 7 дугаар сарын 30 -ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаагаар тус тус сунгасугай.

Хоёр. Сайнцагаан сумын Галтай зэт ХХК-ны хүнсний дэлгүүрүүдийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг тухайн аж ахуйн нэгжийн охин компани Сүлд-Оюу ХХК-ны нэр дээр шилжүүлж эрхийн хугацааг 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

Гурав. Сайнцагаан сумын Хүч хоршооны архи согтууруулах ундаа худалдах, Адуун хишигтэн ХХК-ны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн 2019 оны 7 дугаар сарын 22 -ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн эрхийг сунгуулсан олгосон газруудын худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Тав. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (О.Амарсанаа), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

480190792

Аймгийн Засаг даргын 2019 оны 7 дугаар
сарын 30-ны өдрийн ХХХ дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

Архи согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэх тусгай
зөвшөөрлийг олгосон аж ахуйн нэгжүүдийн жагсаалт

№	Сумын нэр	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Эзэмшигчийн нэр
1	Сайнцагаан	Сүлд-Оюу хайрхан	Худалдаа	С.Доржням
2	Сайнцагаан	Мандалын хурд	Худалдаа	Б.Оюунбат
3	Сайнцагаан	Цоглог ертөнц	Худалдаа	Б.Эрдэнэчимэг
4	Сайнцагаан	Өргөн -Ундраа	Худалдаа	Н.Эрдэнэбаатар
5	Сайнцагаан	ХӨҮМ ЛАНД	Худалдаа	Өлзийхишиг
6	Эрдэнэдалай	Содбилэг далай	Худалдаа	У.Уянга
7	Дэлгэрцогт	Зэст би эс ди	худалдаа	Л.Сэнгэравдан
8	Хулд	Говийн тэргүүн	Үйлчилгээ	Л.Оюунбилэг
9	Сайхан-Овоо	Онгийн нууц	Жуулчны бааз	С.Ундармаа
10	Адаацаг	Эрдэнэ-Ухаа	Жуулчны бааз	Х.Ганбаатар
11	Гурвансайхан	Төв боржигон тур	Жуулчны бааз	Б.Цэрэнчунт
12	Сайхан-Овоо	Цогтын шар мөрөн	Жуулчны бааз	Амарсанаа
13	Сайхан-Овоо	Дундговь ХХК	Жуулчны бааз	А.Баярсайхан